



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/016/НА-СТА-ТТЗ

Баянхонгор 2025 он Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Аудитын менежер Утас: 99061829 Аудитор Утас: 88114307	Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> М.Алтантуяа Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a> Ц.Дорж Цахим хаяг: <a href="mailto:Dorjts@audit.gov.mn">Dorjts@audit.gov.mn</a>
---	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	8
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	17
3.5.1. Мөнгөн хөрөнгө.....	17
3.5.2 Авлага.....	17
3.5.3 Бараа материал.....	18
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	19
3.5.8 Өр төлбөр.....	20
Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	20
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	21
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	21
3.7 Орлогын данс.....	21
3.8 Зардлын данс.....	22
3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	23
<b>АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	25
4.1. Ерөнхий зүйл.....	25
4.2 Материаллаг байдал.....	26
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	26
4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	26
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	27
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	27
4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	27
4.9 Аудитын гол асуудал.....	27
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	30

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Т.БЯМБАДОРЖ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.03.10 № 2/110

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зөрчил нь гүйцэтгэлийн материаллаг байдлаас давсан.

Баян-овоо сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 715,377.8 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 715,377.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага өгч сумын ЗДТГ -ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгсөн байна.

Сумын Засаг даргын төвлөрүүлэн захирагчийн тайланд 2 алдаа, зөрчил илэрснээс 2 албан шаардлага өссөн байна.

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 2,320.4 мянга, газрын төлбөрийн орлого 18,412.2 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1,500.0 мянга, Хог хаягдлын

6425020508

хураамж 3,100.8 мянга, ан агнуурын ашигласны нөөцийн төлбөрийг 856,080.0 мянган төгрөгөөр тасарсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9 дэх “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.7 дахь “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 дахь “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баян-овоо сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны биелэлтийг 92.3 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ









**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>793,942.8</b>	<b>1,205,503.2</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>222,103.1</b>	<b>397,152.4</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>222,103.1</b>	<b>397,152.4</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>222,103.1</b>	<b>397,152.4</b>
31211	Төрийн сангийн харилцах	222,103.1	397,152.4
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>384,475.5</b>	<b>533,645.0</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,279.2	1,199.2
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>299,815.0</b>	<b>481,519.5</b>
33510	Байгууллагаас авах авлага	265,925.0	187,538.0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	33,890.0	293,981.5
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>81,381.3</b>	<b>50,926.3</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>81,381.3</b>	<b>50,926.3</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	81,381.3	50,926.3
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>177,364.2</b>	<b>264,705.8</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,897.2</b>	<b>15,295.0</b>
35110	Тусгай зориулалттай материал	4,897.2	15,295.0
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>164,865.7</b>	<b>243,271.2</b>
35410	Бичиг хэргийн материал	2,832.1	986.1
35420	Аж ахуйн материал	94,521.0	46,369.4
35440	Түлш, шатах тослох материал	3,259.6	922.7
35450	Барилгын засварын материал	1,005.5	850.0
35470	Бусад хангамжийн материал	63,247.5	194,143.0
35600	Мал амьтад	7,601.3	6,139.6
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>10,000.0</b>	<b>10,000.0</b>
36600	Бусад нөөц	10,000.0	10,000.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,911,412.9</b>	<b>2,408,047.6</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,911,412.9</b>	<b>2,408,047.6</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,782,906.9</b>	<b>2,279,697.6</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,756,427.0	2,024,156.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(398,461.6)	(461,703.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	321,753.8	467,994.9
39204	Хуримтлагдсан элэгдэл	(161,027.1)	(210,424.6)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	318,972.0	377,391.7
39206	Хуримтлагдсан элэгдэл	(221,906.8)	(256,743.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,089.9	87,589.9
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,120.3)	(55,403.8)
39214	Бусад үндсэн хөрөнгө	236,736.4	423,791.9
39215	Хуримтлагдсан элэгдэл	(95,356.2)	(122,751.5)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	5,800.0	5,800.0
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>128,506.0</b>	<b>128,350.0</b>
39301	Програм хангамж	780.0	780.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(546.0)	(702.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	128,272.0	128,272.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,705,355.8</b>	<b>3,613,550.8</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>123,089.2</b>	<b>69,663.3</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>123,089.2</b>	<b>69,663.3</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>123,089.2</b>	<b>69,663.3</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	542.8	4,505.4
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,527.2	-
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>116,019.2</b>	<b>65,157.9</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	116,019.2	64,367.9

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	790.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,582,266.5</b>	<b>3,543,887.5</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,582,266.5</b>	<b>3,543,887.5</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	530,810.9	530,810.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	530,810.9	530,810.9
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,779,318.6</b>	<b>2,740,939.6</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,722,531.3	1,779,318.6
51220	Тайлант үеийн үр дүн	56,787.3	961,621.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	272,137.1	272,137.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,705,355.8</b>	<b>3,613,550.8</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,453,107.7</b>	<b>4,723,935.2</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>2,373,816.1</b>	<b>3,167,787.4</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>1,325,396.6</b>	<b>2,366,175.5</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>1,325,396.6</b>	<b>2,366,175.5</b>
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	1,287,551.7	2,227,807.7
110002	Үйл ажиллагааны орлого	23,714.2	126,858.5
110003	Хөрөнгийн орлого	8,064.6	8,468.9
110004	Хөрөнгө борлуулсны орлого	6,066.1	3,040.4
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>184,625.1</b>	<b>158,641.2</b>
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	25,366.1	25,579.2
113002	Бууны албан татвар	1,035.0	1,170.0
113004	Малд ногдуулах албан татвар	158,224.0	131,892.0
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>863,794.4</b>	<b>642,970.7</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>19,696.1</b>	<b>15,032.8</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,508.1	1,233.6
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,000.0	4,500.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,188.0	9,299.2
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>28,416.4</b>	<b>21,568.0</b>
118101	Газрын төлбөр	28,416.4	21,568.0
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>814,320.0</b>	<b>606,370.0</b>
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	814,320.0	605,520.0
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	850.0
<b>1183</b>	<b>Бусад татвар</b>	<b>1,362.0</b>	<b>-</b>
118301	Бусад татвар	1,362.0	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>548,067.4</b>	<b>1,087,960.6</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>548,067.4</b>	<b>877,960.6</b>
120003	Торгуулийн орлого	28,466.5	22,045.0
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>203,373.0</b>	<b>203,383.5</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	203,183.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	203,373.0	200.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	227,741.7	199,585.4
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	88,486.2	452,946.7
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>-</b>	<b>210,000.0</b>
122001	Хандив тусламж /дотоод/	-	210,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,531,224.2</b>	<b>468,187.1</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,777.9</b>	<b>55,403.7</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,929.4	26,253.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,848.4	29,150.8
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,496,446.3</b>	<b>408,518.3</b>

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,273,755.9	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	12,951.0	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	209,739.4	408,518.3
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	<b>4,265.1</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,265.1
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,338,565.9</b>	<b>3,762,314.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,338,565.9</b>	<b>3,762,314.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,746,893.9</b>	<b>3,186,373.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>554,149.3</b>	<b>803,060.8</b>
210101	Үндсэн цалин	553,939.8	803,060.8
210105	Гэрээт ажлын хөлс	209.5	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,676.1</b>	<b>100,061.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,233.3	69,063.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,958.8	7,645.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,420.7	4,033.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,081.1	3,615.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,982.3	15,704.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>389,354.8</b>	<b>455,544.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,999.6	41,972.3
210302	Түлш, халаалт	350,855.2	409,540.8
210303	Цэвэр, бохир ус	3,500.0	4,031.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>252,652.5</b>	<b>196,361.4</b>
210401	Бичиг хэрэг	10,347.3	17,021.0
210402	Тээвэр, шатахуун	38,094.2	53,636.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,024.5	4,633.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,620.0	20,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,566.5	26,432.3
210408	Бараа материал акталсны зардал	-	74,037.5
210409	Бараа материал шилжүүлсний зардал	150,000.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,153.5</b>	<b>47,848.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,005.0	9,140.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,280.0	-
210604	Урсгал засвар	20,868.5	38,708.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,426.0</b>	<b>23,270.0</b>
210702	Дотоод албан томилолт	14,426.0	23,270.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,096,362.9</b>	<b>845,725.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,083,350.6	838,923.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750.0	800.0
210803	Даатгалын үйлчилгээ	969.1	659.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,081.3	549.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319.0	238.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,710.0	960.5
210807	Газрын төлбөр	6,182.9	3,593.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>342,118.9</b>	<b>714,501.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,037.0	512,110.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,885.6	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	201,196.3	202,390.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,591,672.0</b>	<b>575,940.4</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.0</b>	<b>547,064.1</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	300,000.0	547,064.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700.0</b>	<b>28,876.3</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	700.0	4,800.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	23,876.3

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,290,972.0</b>	<b>-</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	2,273,755.9	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,951.0	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,265.1	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>114,541.8</b>	<b>961,621.0</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>57,754.6</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	57,754.6	-
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>56,787.3</b>	<b>961,621.0</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,810.9	299,846.3	1,694,822.1	2,525,479.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	27,709.2	27,709.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	530,810.9	299,846.3	1,722,531.3	2,553,188.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(27,709.2)	-	(27,709.2)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	56,787.3	56,787.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,810.9	272,137.1	1,779,318.6	2,582,266.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	530,810.9	272,137.1	1,779,318.6	2,582,266.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	530,810.9	272,137.1	1,779,318.6	2,582,266.5
19	Тайлант үеийн үр дүн	-	-	961,621.0	961,621.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	530,810.9	272,137.1	2,740,939.6	3,543,887.5

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,213,589.1</b>	<b>4,032,570.6</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>2,373,816.1</b>	<b>3,167,787.4</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>1,325,396.6</b>	<b>2,366,175.5</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>1,325,396.6</b>	<b>2,366,175.5</b>
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	1,287,551.7	2,227,807.7
110002	Үйл ажиллагааны орлого	23,714.2	126,858.5
110003	Хөрөнгийн орлого	8,064.6	8,468.9
110004	Хөрөнгө борлуулсны орлого	6,066.1	3,040.4
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>184,625.1</b>	<b>158,641.2</b>
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	25,366.1	25,579.2
113002	Бууны албан татвар	1,035.0	1,170.0
113004	Малд ногдуулах албан татвар	158,224.0	131,892.0
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>863,794.4</b>	<b>642,970.7</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>21,058.0</b>	<b>15,032.8</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,508.1	1,233.6
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,000.0	4,500.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,188.0	9,299.2
118011	Бусад татвар	1,362.0	-
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>28,416.4</b>	<b>21,568.0</b>

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

118101	Газрын төлбөр	28,416.4	21,568.0
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>814,320.0</b>	<b>606,370.0</b>
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	814,320.0	605,520.0
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	850.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>308,548.9</b>	<b>396,596.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>308,548.9</b>	<b>186,596.0</b>
120003	Торгуулийн орлого	28,466.5	22,045.0
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>280,082.4</b>	<b>164,551.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,082.4	164,351.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	200.0
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>-</b>	<b>210,000.0</b>
122001	Хандив тусламж /дотоод/	-	210,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,531,224.2</b>	<b>468,187.1</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,777.9</b>	<b>55,403.7</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,929.4	26,253.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,848.4	29,150.8
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,496,446.3</b>	<b>408,518.3</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,273,755.9	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	12,951.0	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	209,739.4	408,518.3
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>-</b>	<b>4,265.1</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,265.1
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,895,122.6</b>	<b>2,558,725.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,895,122.6</b>	<b>2,558,725.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,303,150.6</b>	<b>1,982,784.7</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>544,982.3</b>	<b>804,654.3</b>
210101	Үндсэн цалин	350,847.0	402,149.0
210102	Нэмэгдэл	140,699.3	309,682.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,219.0	45,651.8
210104	Урамшуулал	22,007.6	47,170.8
210105	Гэрээт ажлын хөлс	209.5	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,924.2</b>	<b>94,643.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,837.6	62,277.1
210202	Тэтгэмжийн даатгал	6,021.6	8,241.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,787.8	4,205.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,233.9	4,178.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,043.4	15,740.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>382,827.6</b>	<b>453,039.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,999.6	42,097.3
210302	Түлш, халаалт	344,328.0	407,036.4
210303	Цэвэр, бохир ус	3,500.0	3,906.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>88,003.5</b>	<b>81,211.4</b>
210401	Бичиг хэрэг	6,262.7	9,709.9
210402	Тээвэр, шатахуун	39,273.8	34,153.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,436.6	4,027.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,020.0	20,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,010.4	12,720.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,469.7</b>	<b>46,740.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,220.0
210604	Урсгал засвар	24,469.7	42,520.4
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,786.0</b>	<b>22,420.0</b>
210702	Дотоод албан томилолт	14,786.0	22,420.0

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>47,424.1</b>	<b>248,728.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,703.8	240,379.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750.0	800.0
210803	Даатгалын үйлчилгээ	969.1	659.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,096.0	579.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319.0	209.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,418.0	2,507.5
210807	Газрын төлбөр	6,168.2	3,593.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>124,733.3</b>	<b>231,347.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,011.0	231,347.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,722.3	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,591,972.0</b>	<b>575,940.4</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.0</b>	<b>547,064.1</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	300,000.0	547,064.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000.0</b>	<b>28,876.3</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	23,876.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0	5,000.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,290,972.0</b>	<b>-</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	2,273,755.9	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,951.0	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,265.1	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,318,466.5</b>	<b>1,473,845.5</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,423,197.6</b>	<b>1,298,796.2</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,423,197.6</b>	<b>1,298,796.2</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,423,197.6</b>	<b>1,298,796.2</b>
220001	Барилга байгууламж	1,224,867.8	799,356.3
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	198,329.7	499,439.9
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(1,423,197.6)</b>	<b>(1,298,796.2)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(104,731.1)</b>	<b>175,049.3</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	326,834.2	222,103.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	222,103.1	397,152.4

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,531,826.3</b>	<b>3,261,075.2</b>	<b>1,270,751.1</b>	<b>72.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,828,496.8</b>	<b>2,461,718.9</b>	<b>366,777.9</b>	<b>87.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,822,996.8</b>	<b>2,456,718.9</b>	<b>366,277.9</b>	<b>87.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>889,482.2</b>	<b>804,654.3</b>	<b>84,827.9</b>	<b>90.5</b>
210101	Үндсэн цалин	422,270.4	402,149.0	20,121.4	95.2
210102	Нэмэгдэл	346,869.1	309,682.7	37,186.4	89.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,312.0	45,651.8	2,660.2	94.5
210104	Урамшуулал	72,030.7	47,170.8	24,859.9	65.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>111,185.0</b>	<b>94,643.1</b>	<b>16,541.9</b>	<b>85.1</b>

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	75,605.8	62,277.1	13,328.7	82.4
210202	Тэтгэмжийн даатгал	8,894.8	8,241.9	652.9	92.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,447.4	4,205.4	242.0	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	4,447.4	4,178.2	269.2	93.9
210205	Эрүүл мэндийн даатгал	17,789.6	15,740.5	2,049.1	88.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>477,503.2</b>	<b>453,039.7</b>	<b>24,463.5</b>	<b>94.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	47,700.0	42,097.3	5,602.7	88.3
210302	Түлш, халаалт	424,603.2	407,036.4	17,566.8	95.9
210303	Цэвэр, бохир ус	5,200.0	3,906.0	1,294.0	75.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>84,911.3</b>	<b>81,211.4</b>	<b>3,699.9</b>	<b>95.6</b>
210401	Бичиг хэрэг	11,694.1	9,709.9	1,984.2	83.0
210402	Тээвэр, шатахуун	34,040.0	34,153.6	(113.6)	100.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,156.9	4,027.3	1,129.6	78.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,620.7	20,600.0	20.7	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,399.6	12,720.6	679.1	94.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>347,610.0</b>	<b>287,978.8</b>	<b>59,631.2</b>	<b>82.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,008.0	18,429.4	36,578.6	33.5
210604	Урсгал засвар	292,602.0	269,549.4	23,052.6	92.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>22,450.0</b>	<b>22,420.0</b>	<b>30.0</b>	<b>99.9</b>
210702	Дотоод албан томилолт	22,450.0	22,420.0	30.0	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>260,816.9</b>	<b>257,869.0</b>	<b>2,947.9</b>	<b>98.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,606.9	249,520.1	1,086.8	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100.0	800.0	300.0	72.7
210803	Даатгалын үйлчилгээ	1,000.0	659.5	340.5	65.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	850.0	579.3	270.7	68.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500.0	209.0	291.0	41.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,156.3	2,507.5	648.8	79.4
210807	Газрын төлбөр	3,603.7	3,593.7	10.0	99.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>629,038.2</b>	<b>454,902.7</b>	<b>174,135.5</b>	<b>72.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	628,038.2	454,902.7	173,135.5	72.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,500.0</b>	<b>5,000.0</b>	<b>500.0</b>	<b>90.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,500.0</b>	<b>5,000.0</b>	<b>500.0</b>	<b>90.9</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500.0	5,000.0	500.0	90.9
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,703,329.5</b>	<b>799,356.3</b>	<b>903,973.2</b>	<b>46.9</b>
220001	Барилга байгууламж	1,703,329.5	799,356.3	903,973.2	46.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,531,826.3</b>	<b>3,426,697.4</b>	<b>1,105,128.9</b>	<b>75.6</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,196,599.4</b>	<b>3,052,146.4</b>	<b>144,453.0</b>	<b>95.5</b>
320001	Орон нутгийн төсвөөс	3,196,599.4	2,643,628.1	552,971.3	82.7
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>319,291.1</b>	<b>164,551.0</b>	<b>154,740.1</b>	<b>51.5</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,327.5	164,351.0	(103,023.5)	268.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,000.0	200.0	100,800.0	0.2
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>583,007.7</b>	<b>210,000.0</b>	<b>373,007.7</b>	<b>36.0</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	583,007.7	210,000.0	373,007.7	36.0

<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>52</b>	<b>52</b>	<b>-</b>	<b>100</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100</b>
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>-</b>	<b>100</b>
620001	Удирдах ажилтан	9	9	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	100
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100
620004	Гэрээт ажилтан	1	1	-	100
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>-</b>	<b>100</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	-	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	-	100
650010	Гэрээт ажилтан	1	1	-	100
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	-	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэлийн дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>55,403.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>55,403.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>25,505.7</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,059.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,059.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,446.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,446.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,898.1</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,876.3</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,876.3
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,021.7</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,021.7
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>55,403.7</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,403.7</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,253.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,150.8

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх иргэдийн хууль ёсны эрх ашигийг хамгаалах ардчилал, шударга есыг тогтоох хууль дээдлэх төрийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, ажил үйлчилгээг хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй явуулах, төсөв санхүүгийн хэмжээг тодорхойлох эцсийн үр дүнг үнэлж дүгнэх нийгмийн үйлчилгээний чанар үр ашгийг дээшлүүлэхэд гол зорилго оршино.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-овоо сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүний хөгжил, уламжлалт ёс заншлаа дээдлэн, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл,

үйлчилгээ, аялал жуулчлал хөгжсөн, эдийн засгийг тогтворжуулж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан Хөдөө аж ахуйн салбарын хөгжлөөр аймагтаа Тэргүүлэгч сум болно.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд: Хүний хөгжлийн дээдлэн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй дэмжиж иргэдийг тогтвортой ажлын байраар хангах, ядуурлыг бууруулахад төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх нь байгууллагын эрхэм зорилт юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Баян-овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 908,195.1 мянган төгрөгөөр буюу 35.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	793,942.8	29.3	1,205,503.2	33.4	411,560.4	45.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	222,103.1	28.0	397,152.4	32.9	175,049.3	42.5
АВЛАГА	384,475.5	48.4	533,645.0	44.3	149,169.5	36.2
УРЬДЧИЛГАА			-		-	
БАРАА МАТЕРИАЛ	177,364.2	22.3	264,705.8	22.0	87,341.60	21.2
НӨӨЦИЙН БАРАА	10,000.0	1.3	10,000.0	0.8	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,911,412.9	70.7	2,408,047.6	66.6	496,634.7	54.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,838,830.9	70.7	3,515,776.3	66.6	676,945.4	54.7
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(927,418.0)	(32.7)	(1,107,728.7)	(31.5)	(180,310.7)	(26.6)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,705,355.7</b>	<b>100</b>	<b>3,613,550.8</b>	<b>100</b>	<b>908,195.1</b>	<b>100</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	123,089.2	4.5	69,663.3	1.9	(53,425.9)	(5.9)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,582,266.5	95.5	3,543,887.5	98.1	961,621.0	105.9
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,705,355.7</b>	<b>100</b>	<b>3,613,550.8</b>	<b>100</b>	<b>908,195.1</b>	<b>100</b>

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

**3.5.1. Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 222,103.1 мянган төгрөг байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 397,152.4 мянган төгрөг болж 175,049.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө	222,103.1	397,152.4	175,049.3	42.5
<b>Дүн</b>	<b>222,103.1</b>	<b>397,152.4</b>	<b>175,049.3</b>	<b>42.5</b>

*Эх сурвалж: Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 397,152.4 мянган төгрөг нь орон нутгийн Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 65,852.5 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 210,494.1 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 120,805.8 мянган төгрөг тус тус байршиж байна.

**3.5.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 384,475.5 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 533,645.0 мянган төгрөг болж 149,169.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	3,279.2	1,199.3	2,079.9
Татаас санхүүжилтийн авлага			-
Байгууллагаас авах авлага	265,925.0	187,538.0	78,387.0
Хувь хүмүүсээс авах авлага	33,890.0	293,981.5	-260,091.5
Хувь хүмүүст олгосон зээл	81,381.2	50,926.2	30,455.0
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл			-
<b>Дүн</b>	<b>384,475.4</b>	<b>533,645.0</b>	<b>-149,169.5</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 9.5 хувь буюу 50,926.2 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн сангийн авлага, 57.1 хувь буюу 304,519.5 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 0.2 хувь буюу 1,199.2 мянган төгрөг нь ИТХ-ын авлага, 33,2 хувь буюу 177,000.0 мянган төгрөг нь ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар залруулж бүртгэлд тусгасан авлага байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	123.7	177,000.0	176,876.3	33.2
ИТХ	3,180.5	1,199.2	-1,981.3	0.2
Соёл			0.0	0.0
ЭМТ			0.0	0.0
СХС	81,381.2	50,926.3	-30,454.9	9.5
Цэцэрлэг			0.0	0.0
ЕБС			0.0	0.0
ОНХСан	299,790.0	304,519.5	4,729.5	57.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>384,475.4</b>	<b>533,645.0</b>	<b>149,169.6</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 187,364.2 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 274,705.8 мянган төгрөг болж, 87,341.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	4,897.2	15,295.0	10,397.8
Бичиг хэргийн материал	2,832.1	986.1	-1,846.0
Аж ахуйн материал	94,521.0	46,369.4	-48,151.6
Түлш, шатах тослох материал	3,259.6	922.7	-2,336.9
Барилгын засварын материал	1,005.5	850.0	-155.5
Бусад хангамжийн материал	63,247.5	194,143.0	130,895.5
Нөөцийн бараа	10,000.0	10,000.0	0.0
Мал амьтад	7,601.3	6,139.6	-1,461.7
<b>Дүн</b>	<b>187,364.2</b>	<b>274,705.8</b>	<b>87,341.6</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 274,705.8 мянган төгрөг болж өмнөх оноос 87,341.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	2,442.9	18,978.1	16,535.2	6.9
ЗДТГ	174,921.3	245,727.7	70,806.4	89.5
Соёл			-	-
ЭМТ			-	-
ОНХС	10,000.0	10,000.0	-	3.6
ЕБС			-	-
Цэцэрлэг			-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>187,364.2</b>	<b>274,705.8</b>	<b>87,341.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Тайлант онд нийт нэмэгдсэн 87,341.6 мянган төгрөгийн бараа материалаас 269,102.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 452,578.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хандиваар, 368.0 мянган төгрөгийн бараа материалыг бусдаар авсан байна. Мөн нийт хасагдсан 634,707.9 мянган төгрөгийн бараа материалаас 560,670.3 мянган төгрөгийг зарцуулсан, 74,037.5 мянган төгрөгийг бусдаар зарцуулсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	722,049.5	Хасагдсан	634,707.9
Худалдан авсан	269,102.8	Худалдсан, зарцуулсан	560,670.4
Хандиваар	452,578.7	шилжүүлсэн	
Шилжүүлсэн авсан			
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр		бусад	
бусад	368.0	бусад	74,037.5

*Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,838,830.9 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,515,776.3 мянган төгрөг болж 676,945.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	2,709,778.9	3,386,724.3	676,945.4	96.3
Барилга байгууламж, орон сууц	1,756,427.0	2,024,155.9	267,728.9	57.6
Тээврийн хэрэгсэл	321,753.8	467,994.9	146,241.1	13.3
Машин тоног төхөөрөмж	318,972.0	377,391.7	58,419.7	10.7
Тавилга эд хогшил	70,089.8	87,589.9	17,500.1	2.5
Зам гүүрийн байгууламж			0.0	0.0
Дуусаагүй барилга байгууламж	5,800.0	5,800.0	0.0	0.2
Номын фонд			0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	236,736.3	423,791.9	187,055.6	12.1
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	129,052.0	129,052.0	0.0	3.7
Программ хангамж	780.0	780.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	128,272.0	128,272.0	0.0	3.6
<b>НИЙТ ДҮН</b>	2,838,830.9	3,515,776.3	676,945.4	100.0

*Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө нь 676,945.4 мянган төгрөгөөр өссөн бөгөөд үүний шалтгаан нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд хуучин цэцэрлэгийн барилгын засварын ажлын 267,729.0 төгрөгөөр сайжруулалт хийгдсэн, цагдаагийн албан хэрэгцээний авто машин, тусгай тоноглол бүхий ачааны машин зэргийг хандиваар, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 79,860.0 мянган төгрөгөөр бохир соруулах машин, 20,000.0 мянган төгрөгөөр 5 мотоцикл байгаль хамгаалагч нарт Засаг даргын нөөц хөрөнгө, аймгийн хөрөнгө оруулалтаар 1 мотоцикл, мотоблок 11,281.1 мянган төгрөг, цагдаагийн машин 20,000.0, Иргэдийн хурлын 35,000 төгрөгийн ачааны машин хандиваар, бусад үндсэн хөрөнгөнд байгууллагын гадна хайс 17,055.0 мянган төгрөг, хөв цөөрөм ан амьтны камержуулалт 160,000.0 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар 10,000.0 мянган төгрөгийн хүлэмж байна.

Үндсэн хөрөнгийн тооллогоор Хадлангийн трактор, Хөрөө рам, малын зөөврийн хашаа зэрэг 31,167.2 мянган төгрөгийн хөрөнгүүд биетээр байхгүй ЗДТГ-ын аудитаар зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.



**Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	14,102.0	52,026.5	37,924.5	2.2
ЗДТГ	1,897,310.9	2,356,021.1	458,710.2	97.8
Соёл			0.0	0.0
ЕБС			0.0	0.0
Цэцэрлэг			0.0	0.0
Эмнэлэг			0.0	0.0
ОНХСан			0.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,911,412.9</b>	<b>2,408,047.6</b>	<b>496,634.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 496,634.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 71.4 хувь буюу 499,439.9 мянган төгрөгийг хөрөнгийг худалдан авалтаар авсан нь голлох нөлөө үзүүлж байна .

**Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/**

Нэмэгдсэн	699,025.3	Хасагдсан	22,080.00
Худалдан авсан	499,439.9	Худалдсан	
Хандиваар	121,029.0	Акталсан	2,180.00
Шилжүүлэн авсан	39,056.6	Шилжүүлсэн	19900
Бусад	39,499.8	Бусад	

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 123,089.2 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 69,663.3 мянган төгрөг болж 53,425.9 мянган төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	<b>123,089.2</b>	<b>69,663.3</b>	<b>-53,425.9</b>	<b>100.0</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	542.8	4,505.4	3,962.6	6.5
Татаас санхүүжилт шилжүүлгийн өглөг			-	-
Байгууллагад төлөх өглөг	122,546.4	64,367.9	(58,178.5)	92.4
Хувь хүмүүст өгөх өглөг		790.0	790.0	1.1
<b>Дүн</b>	<b>123,089.2</b>	<b>69,663.3</b>	<b>(53,425.9)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 69,663.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь сумын ЗДТГ-ын ХХОАТ 4,505.4 мянган төгрөг, хамтын сангийн 790.0 мянган төгрөг, Эмнэлгийн халаалт 5,099.6 мянган төгрөг, ЗДТГ -ын Шүүхийн шийдвэрт 20,168.2 мянга, ИТХ -ын 200.0 мянган төгрөгийн өрийн үлдэгдэл байна.

**Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ		200.0	200.0	0.3
ЗДТГ	542.8	25,463.7	24,920.9	36.6
Орон нутгийн ерөнхий орлого			-	-
ЕБС			-	-

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

ЭМТ		5,099.6	5,099.6	7.3
ОНХС	116,019.2	38,900.0	(77,119.2)	55.8
Цэцэрлэг	6,527.2		(6,527.2)	-
СХСан			-	-
ДҮН	123,089.2	69,663.3	(53,425.9)	100.0

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,582,266.5 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,543,887.5 мянган төгрөг болж, 961,621.2 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	530,810.9	530,810.9	-	15.0
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	530,810.9	530,810.9	-	15.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,779,318.5</b>	<b>2,740,939.5</b>	<b>961,621.0</b>	<b>77.3</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	272,137.1	272,137.1	-	7.7
<b>Дүн</b>	<b>2,582,266.5</b>	<b>3,543,887.5</b>	<b>961,621.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 961,621.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023.12.19-ний өдрийн хуралдаанаар 12/01 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 2,227,629.7 мянга, хүү торгуулийн орлогыг 20,000.0 мянга, нийт 2,248,629.7 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024.09.25-ний өдрийн 15/01 дугаар тогтоолоор 1,846,231.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Татварын орлого	3,673,860.7	3,157,756.4	(516,104.3)	86.0
ЦХТА рлого /суутган/	1,898,895.7	2,226,541.0	327,645.3	117.3
ҮХЭД хөрөнгийн албан татвар	27,900.0	25,579.6	(2,320.4)	91.7
Бууны татвар	735.0	1,170.0	435.0	159.2
ИОТХ	96,100.0	126,573.0	30,473.0	131.7
Улсын тэмдэгтийн хураамж	1,000.0	1,233.6	233.6	123.4
Хадгаламжийн хүүгийн орлого	6,900.0	9,003.2	2,103.2	130.5
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого	3,000.0	3,040.4	40.4	101.3
Малд ногдуулах албан татвар	116,000.0	122,858.6	6,858.6	105.9
Газрын төлбөр	40,000.0	21,587.8	(18,412.2)	54.0
Газрын дуудлага худалдаа	3,000.0		(3,000.0)	-

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,400.0	9,299.2	(3,100.8)	75.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,461,600.0	605,520.0	(856,080.0)	41.4
ТТАМАТөлбөр	6,000.0	4,500.0	(1,500.0)	75.0
Ус рашаан	330.0	850.0	520.0	257.6
<b>2.Татварын бус орлого</b>	<b>21,000.0</b>	<b>24,495.0</b>	<b>3,495.0</b>	<b>116.6</b>
2.1.Хүү торгуулийн орлого	20,000.0	23,295.0	3,295.0	116.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	1,200.0	200.0	120.0
<b>Нийт дүн</b>	<b>3,695,860.7</b>	<b>3,182,251.4</b>	<b>(512,609.3)</b>	<b>86.1</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 86.1 хувь буюу 512,609.3 мянган төгрөгөөр тасарч биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 327,645.3 бууны албан татвар 435.0 мянга, иргэний орлого тодорхойлох хуудсаар ногдуулсан албан татвар 30,473.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 233.6 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 2,103.2 мянга, малын тоо толгойн албан татвар 6,858.6 мянга, ус рашаан ашигласны төлбөр 520.0 мянга, хүү торгуулийн орлого 3,295.5 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин иргэний үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2,320.4 мянга, газрын төлбөр 18,412.2 мянга, газрын дуудлага худалдааны орлого 3,000.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1,500.0 мянга, хог хаягдлын төлбөр 3,100.8 мянга, ан агнуур ашигласны төлбөр 856,080.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1,200.0 мянган төгрөгийн орлого оруулж үүргээ биелүүлээгүй байна

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 89,599.2 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 30,455.0 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 5,078,890.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,261,075.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2,461,718.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 799,356.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт №14. Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Баян-Овоо сумын Засаг дарга	5,078,890	3,807,989	1,270,902	75
2	70105-80101 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	226,480.0	204,500.0	21,980.0	90.3
3	70105-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	500.0	200.0	300.0	40.0
4	70106-80101 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,358,985.6	1,248,870.7	110,114.9	91.9
5	70106-80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	170,210.3	138,034.6	32,175.7	81.1
6	70106-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	5,000.0	4,800.0	200.0	96.0
7	70106-81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	133,500.0	121,344.3	12,155.7	90.9

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

8	70106-81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	180,000.0	180,000.0	-	100.0
9	70106-82212 хур хог хаягдал, орчны бохирдол	11,020.7	11,000.0	20.7	99.8
10	70106-82310 Гамшгаас хамгаалах	141,700.0	130,254.3	11,445.7	91.9
11	71602-80111 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	49,996.8	43,668.4	6,328.4	87.3
12	71702 -80111 Соёл урлаг	50,693.0	48,235.9	2,457.1	95.2
13	71801 -80111 Сургуулийн өмнөх боловсрол	115,663.1	114,216.2	1,446.9	98.7
14	71802-80111 Ерөнхий боловсрол	236,209.1	216,444.0	19,765.1	91.6
15	70503-80904 Орон нутгийн зорилтот орон оруулалт	571,393.7	136,242.0	435,151.7	23.8
16	70503-83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	353,771.1	269,155.1	84,616.0	76.1
17	70503-83402 Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	12,802.0	-	12,802.0	0.0
18	70503-83403 ОНХС-ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	66,355.0	-	66,355.0	0.0
19	70503-83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	116,000.0	106,953.0	9,047.0	92.2
20	70503-83406 ОНХС- Бусад	583,007.7	287,006.0	296,001.7	49.2
21	70504-80506 Аймагт төвлөрүүлэх	547,064.1	547,064.1	-	100.0
22	72101-82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	148,538.2	-	148,538.2	0.0
	<b>Нийт дүн</b>	<b>5,078,890.4</b>	<b>3,807,988.6</b>	<b>1,270,901.8</b>	<b>75.0</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023.12.19-ний өдрийн хуралдаанаар 12/01 дугаар тогтоолоор нийт 3,232,659.4 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024.09.25-ний өдрийн 15/01 дугаар тогтоолоор 1,846,231.0 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	166,123.8	206,980.0	226,980.0	-60,856.2
Засаг даргын Тамгын газар	892,298.4	1,379,146.7	2,000,416.6	-1,108,118.2
Сургууль	194,209.1	194,209.1	236,209.1	-42,000.0
Цэцэрлэг	104,135.9	104,135.9	115,663.1	-11,527.2
Эрүүл мэндийн төв	49,996.8	49,996.8	49,996.8	0.0
Соёлын төв	48,693.0	48,693.0	50,693.0	-2,000.0
Сум хөгжүүлэх сан	148,538.2	148,538.2	148,538.2	0.0
Орон нутгийн хөгжлийн сан	917,947.9	917,947.9	1,703,329.5	-785,381.6
<b>Нийт дүн</b>	<b>2,521,943.1</b>	<b>3,049,647.6</b>	<b>4,531,826.3</b>	<b>-2,009,883.2</b>

Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023.12.19-ний өдрийн хуралдаанаар 12/01 дугаар тогтоолоор анх 3,232,659.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024.09.25-ний

өдрийн 15/01 дугаар тогтоолоор 1,846,231.0 мянган төгрөгөөр өсгөж 5,078,890.4 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 3,694,860.7 мянган төгрөгийг орон орлогоос санхүүжүүлэх, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 432,928.1 төгрөгийг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 61,752.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 100,000.0 мянган, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 49,802.8 мянган, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 69,752.9 мянган, хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс 87,210.7 мянган төгрөгийг, хандив тусламжийн орлогоор 583,007.7 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөжээ. Мөн аймгийн төсөвт 547,064.1 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр сумын зардлын дүнд оруулан баталсныг 100 хувь олгосон.

Гүйцэтгэлээр аймагт өгсөн санхүүгийн дэмжлэг 547,064.1 мянган, орон нутгийн орлогоос 2,643,628.0 мянган, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 408,518.3 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 133,896.0 мянган төгрөгийн, хандив тусламжийн орлогоос 210,000 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн зээл хүүгийн орлогоос 30,455.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан ба урьд оны үлдэгдлээс санхүүжих санхүүжилтийг бүрэн авч 16,142,8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

<b>Байгууллагын нэр</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Зөрүү</b>	<b>Хувь</b>	<b>ОН</b>
ЗДТГ	2,000,416.6	1,834,303.9	166,112.7	91.7	89,916.9
ИТХ	226,980.0	204,700.0	22,280.0	90.2	10,955.8
Соёлын төв	50,693.0	48,235.9	2,457.1	95.2	5,965.2
Сум хөгжүүлэх сан	148,538.2		148,538.2	0.0	
Сургууль	236,209.1	216,444.0	19,765.1	91.6	15,435.0
Цэцэрлэг	115,663.1	114,216.2	1,446.9	98.7	401.9
ЭМТ	49,996.8	43,668.4	6,328.4	87.3	2,307.6
ОНХС	1,703,329.5	799,356.1	903,973.4	46.9	
<b>Нийт дүн</b>	<b>4,531,826.3</b>	<b>3,260,924.5</b>	<b>1,270,901.8</b>	<b>72.0</b>	<b>124,982.4</b>

*Эх сурвалж: Баян-овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,260,924.5 мянган төгрөг буюу 72 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардал 166,112.7 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 148,538.2 мянган, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 903,973.4 мянган, ИТХ-ын урсгал зардлаас 22,280 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна. Энэ нь Орон нутгийн орлогын гүйцэтгэл тасарсантай холбоотой.

### **3.9.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын Тамгын газрын Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 54,395.5 мянган төгрөг төвлөрснөөс дээд шатны төсвийн захирагчаас ЗДТГ-т хуваарилсан 25,252.9 мянган төгрөг, үүнээс Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчийн 5 жилийн тэтгэмж 23,876.3, хагас жилийн мал

тооллогын зардал 877 мянган төгрөг байна. Бусад 29,142.5 мянган төгрөг нь байгууллагын үйл ажиллагааны орлого ба үүнд Төрийн албан хаагчд, бусад байгууллагаас цаг агаарын нөхцөл байдал хүндэрсэн үед өгсөн хандив, хивэг, тэжээлийн үнийн орлого, байгаль орчны барьцаа зэрэг байна.

Зарцуулсан нь тэтгэмжид 23,876.3 мянган төгрөг, 877 мянган төгрөг нь мал тооллогод, 9242.1 мянган төгрөг нь аймгийн Онцгой байдлын газарт, малчдад олгосон эмийн багцын үнэд 3,120 мянган төгрөг, ахмад настанд олгосон нүүрсний үнэд 4,722.6 мянган төгрөг, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зардалд 2,000 мянган төгрөг, байгууллагын хайсны гагнуурт 3,000 төгрөг тус тус зарцуулж, нийт 48,382 мянган төгрөг зарцуулж, 6013.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 1000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, архивын албан балансын үнэ 8.1 мянган төгрөг, нийт 1,008.1 мянган төгрөг төвлөрснийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1000.0 мянган төгрөг зарцуулж 8.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулж дансны үлдэгдэлгүй байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,008.1</b>	<b>54,395.4</b>	<b>55,403.5</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	25,793.3	26,793.3
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8.1	28,602.1	28,610.2
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>1,000.0</b>	<b>48,381.9</b>	<b>49,381.9</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.0	11,059.3	12,059.3
Бараа үйлчилгээний бусад зардал		13,446.3	13,446.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж		23,876.3	23,876.3
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	<b>8.1</b>	<b>6,013.5</b>	<b>6,021.6</b>

*Эх сурвалж: Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-овоо сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.



Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дүгээр сарын 07-ний өдрийн 92 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Баян-овоо сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Т.Бямбадорж, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Д.Отгонцэцэг нар зурж байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 3,762,314.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 37,623.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 24,455.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### **4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 2024 онд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 128 мэдээллийг хугацаанд нь 15 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл мэдээлэх хугацаа болоогүй байна.

#### **4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баян-овоо сумын Засаг

даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

#### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 алдаа зөрчил илэрснээс зөрчлийг арилгах зөвлөмж, төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа хэрэгжилтийг сумын тамгын газрын даргын 2024 оны 06 дүгээр сарын 20-ний өдрийн 105 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	0	3	0			100
Нийт	1	0	3	0			100

#### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад шаардлагатай тодруулга, төсвийн гүйцэтгэлийн 54.5 дахь тайлан мэдээг бүрэн гаргаж өгөөгүй.

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 133,500.0 төгрөгөөр баталж 121,344.3 мянган төгрөгийг зарцуулж 12,155.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу 15,900.8 мянган төгрөгийг улс, аймаг сумын аварга малчдын шагнал, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөнд, 5,000.0 мянган төгрөгийн нутгийн зөвлөлийн золголтын арга хэмжээнд, 20,000.0 мянган төгрөгийг сумын цагдаагийн албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулж, Цагдаагийн байрны засварын ажилд, 20,000.0 мянган төгрөгийг хүүхдийн цэцэрлэгийн орчныг сайжруулахад, 40,000.0 мянган төгрөгийг “Эрүүл шүд, эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль цэцэрлэгийн хүүхдийн шүдний үзлэг эмчилгээний төлбөрт, 20,443.5 мянган төгрөгийг Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой мал тооллого, сурагчдын хичээлийн багц, малын дархлаажуулалт, Алтан намар үзэсгэлэн худалдааны шагнал зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

#### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 92.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 5,078,890.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 3,807,988.6 мянган төгрөгийг зарцуулж 75 хувийн биелэлттэй байна.

- Тус сум нь 16 нэр төрлийн орлогоор 3,694,860.70 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 3,190,500.10 мянган төгрөгийг төвлөрүүлж сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 86.3 хувьтай биелж, 504,360.60 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Баян-овоо сумын Засаг даргын харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд түүвэрт хамруулж, ЗДТГ-ын тайланд “Сөрөг” дүгнэлт өгч санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЗДТГ	1	1	1					1	
ИТХурал	1	1		1					
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 896,373.8 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 180,996.0 мянган төгрөгийн 2 залруулга, 431,695.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
ИТХурал	0	0								
ЗДТГ	4	401667.2	1	177,000.0			3	224,667.2		
ОНХСан	2	208996	1	3,996.0			1	205,000.0		
ЭМТ	0	0								
СХС	1	2028.5					1	2,028.5		
СТА зөрчлийн дүн	7	612,691.7	2	180,996.0	-	-	5	431,695.7	-	-
<b>СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
ЗДТГ	1	277,682					1	277,682		-
ОНХСан	0	-								-
ИТХурал	1	6,000.0					1	6,000.0		-

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

СХС	0	-								
Нийцлийн аудитын дүн	2	283,682	-	-	-	-	2	283,682		-
Нийт дүн	9	896,374	2	180,996	0	-	7	715,378	0	-

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдсан зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 612,691.7 мянган төгрөгийн 7 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 283,682.1 мянган төгрөгийн 2 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
<b>Засаг даргын Тамгын газар</b>		<b>679,349.3</b>			
1	Баянхонгор аймаг дахь сум Дундын Иргэний Хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 131/ШШ2023/000799 дугаар шүүгчийн захирамжаар 47,000.0 мянган төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн 131/ШШ2024/00004 дугаар шүүхийн шийдвэрээр 130,000.0 мянган төгрөг нийт 177,000.0 мянган төгрөгийг хариуцагч Баян-овоо сумын Засаг даргын тамгын газраар төлүүлэхээр гарсан байна.	177,000.0	Залруулга	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
2	Үндсэн хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актаар илүүдэл дутагдал байхгүй гэсэн боловч Хадлангийн трактор, Хөрөө рам, малын зөөврийн хашаа зэрэг 31,167.2 мянган төгрөгийн хөрөнгүүд биетээр тоологдоогүй дутсан байна.	31,167.2	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
3	Баян-овоо сумын ЗДТГ -ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 20 -ний өдрийн А/12 тушаалаар суурьшлын бүсийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны төлбөр болох 16,500.0 мянган төгрөгийг шилжүүлэх дээ Э баримтын нэхэмжлэлгүй гүйлгээг хийсэн байна.	16,500.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
4	Шүүхийн шийдвэрт тусгасан нийт 177,000.0 мянган төгрөг Засаг даргын тамгын газрын дансанд орж ирээгүй төсвөөс гадуур зарцуулсан ямар эх үүсвэрт зарцуулсан тодорхойгүй	177,000.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
5	Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг" -д заасан 10 гүйлгээний 356,682,1 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн Ерөөл нэмэх ХХК -тай 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдөр байгуулсан 160,000.0 мянган төгрөгийн гэрээг мэдээлээгүй байна.	277,682.1	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
<b>Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>		<b>6,000.0</b>			
1	Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг" -д заасан 1 гүйлгээний 6,000. мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	6,000.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Батбаатар Л.Алимаа
<b>Сум хөгжүүлэх сан</b>		<b>2,028.5</b>			
1	Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн Б.Цогтбаатар 2013 онд 3,000.0 мянган төгрөг зээл авсан ба зээлийн үлдэгдэл 2,028.5 мянган төгрөгийг төлөөгүй хугацаа хэтэрсэн байна.	2,028.5	Албан шаардлага	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	Т.Бямбадорж Д.Отгонцэцэг Э.Мөнх-эрдэнэ
<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>		<b>208,996.0</b>			
1	Санхүүгийн тайланд авлагыг илүү тусгасан	3,996.0	Залруулга	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	Т.Бямбадорж Д.Отгонцэцэг Э.Мөнх-эрдэнэ

**Баян-овоо сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

				Нягтлан бодогч	
2	Баянхонгор аймагт хөрөнгө оруулах 2021.05.31 -ний 2021/125 дугаар гэрээний "Наранмандал энтерпрайзэйс" ХХЗ -аас орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх 205,000.0 мянган төгрөгийн хандивын орлогыг дансанд төвлөрүүлээгүй зарцуулсан байна.	205,000.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	Т.Бямбадорж Д.Отгонцэцэг Э.Мөнх-эрдэнэ
	<b>Нийт дүн</b>	<b>896,373.8</b>			

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс 2 албан шаардлага 1 зөвлөмж өгөв.

Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан тул Төрийн аудитын тухай хуулийн 42.1 дэх заалтын дагуу Тамгын газрын дарга М.Жавзансүрэнд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.1 Албан шаардлага**

5.1.1 Баян-овоо сумын сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг ирүүлэхдээ УСНББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт дагуу “санхүүгийн тайлангийн тодруулга” бэлтгэж ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг бичиж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Баян-овоо сумын Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ -аар батлуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн тайланг ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

**5.2.1 Бүртгэл тайлагналттай холбоотой**

Илрүүлэлт: Баян-овоо сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 896,373.8 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа төсвийн байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилга, бат, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж өөрийн эрхлэх асуудлын хүрээний дотоод хяналтыг сайжруулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайлан цэвэрлээгүй	1	2,681,935.5			1	2,681,935.5	1	2,681,935.5		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,681,935.5</b>			<b>1</b>	<b>2,681,935.5</b>	<b>1</b>	<b>2,681,935.5</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баян-овоо сумын сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг ирүүлэхдээ УСНББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт дагуу “санхүүгийн тайлангийн тодруулга” бэлтгэж ирүүлээгүй.	1	-			1	-		
Баян-овоо Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ -аар батлуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн тайланг ирүүлээгүй байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								

-----oOo-----

